


















**Сайн гараа 2018**

1. Сайнаа  $4 \times 4$  хэмжээтэй хүснэгтийн нүд бүрд тоо бичиж мөр болон баганын дагуух 4 тооны нийлбэрийг олжээ. Ижил дүрс ижил тоо бол эхний баганад бичигдсэн 4 тооны нийлбэр хэд вэ?

				48
				50
				38
				40
?	50	43	42	

2. Дүрсийг тус бүр нь 2 од агуулсан байхаар дөрвөн ижил дүрсэд хуваа.



3. Самбарт  $1, 2, 3, \dots, 2018$  тоонууд бичсэн байв. Эхлээд бүх сондгой тоонуудыг арчиж, үлдсэн тоонуудаас сондгой байранд байрлах тоонуудыг арчих гэх мэтээр нэг ширхэг тоо үлдтэл нь үргэлжлүүлэв. Самбарт ямар тоо үлдэх вэ?

4. 1-ээс 12 хүртэлх тоонуудыг 3 мөр, 4 баганатай хүснэгтийн нүднүүдэд нэг мөрөнд буй аль ч хоёр тооны ялгавар 3-т хуваагддаг ба нэг баганад байгаа аль ч хоёр тооны ялгавар 4-т хуваагддаг байхаар хэдэн янзаар байрлуулж болох вэ? Нэг боломжийг байрлуулж үзүүл.